



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 124,999,875.00 /нэг зуун хорин дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга найман зуун далан таван/ төгрөгийн балансын үнэ, 79,613,015.64 /далан есөн сая зургаан зуун арван гурван мянга арван таван төгрөг жаран дөрвөн мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээд /Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/-д эзэмшүүлэх, ашиглуулах, данс, бүртгэлд тусгах, ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА




3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГӨЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ 0347

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
191 дугаар тогтоолын хавсралт



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хууримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Ландкруйзер-200, 91-79 УАЕ арал № JTMHV09J8C4088079	2012/ 2014	124,999,875.00	79,613,015.64
	Нийт дүн		124,999,875.00 /нэг зуун хорин дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга найман зуун далан таван/	79,613,015.64 /далан есөн сая зургаан зуун арван гурван мянга арван таван төгрөг жаран дөрвөн мөнгө/